

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ШААРДАГДАХ БАРИМТ
БИЧГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Үйлчилгээний төрөл	Тэтгэмж авах эрх үүсэх, Тэтгэмжийн хувь хэмжээ	Бүрдүүлэх баримт бичиг
ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ			
1	<u>Энгийн өндөр насны тэтгэвэр</u>	-Шимтгэл төлсөн байвал зохих хугацаа: 2019 онд-20 жил 6 сар ба түүнээс дээш -Нас: эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 нас хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл	-Өргөдөл -Нийгмийн даатгалын дэвтэр -Хөдөлмөрийн дэвтэр -Хугацаат цэргийн албыг байлдагч, түрүүчээр хаасан бол цэргийн батлах -1995 оноос өмнөх 5 жилийн цалин хөлсийг сонгосон тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан цалин хөлсний тодорхойлолт эсхүл архивын лавлагаа -Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл -Иргэний үнэмлэх -2 хувь цээж зураг /3x4/
2	<u>4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эхийн тэтгэвэр</u>	-Шимтгэл төлсөн байвал зохих хугацаа: 20 жил - Нас:эмэгтэй 50 нас хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл	
3	<u>Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн тэтгэвэр</u>	Даатгуулагч нь нийтдээ 20-с доошгүй жил, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн тохиолдолд өөрөө хүсвэл харгалзах насанд хүрээд тэтгэврээ тогтоолгох боломжтой.	
4	<u>Ажил мэргэжлийн нөхцөлийн тэтгэвэр</u>	Даатгуулагч доорхи ажил мэргэжлээр 20-иос доошгүй жил эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил үүнээс 15-аас доошгүй жил тухайн ажил мэргэжлээр ажилласан бол өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно./ Гоцлол дуучин, Бүжигчин, Найрал хөгжмийн үлээвэр хөгжимчин, Агаарын болон хэрэглэлийн гимнастик, Акробат, Тэнцвэр, уран нугаралт, Хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, Зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, Хөөмийчин ,Найрал хөгжмийн үлээвэр хөгжимчин/	
5	<u>Бусад нөхцөлийн тэтгэвэр</u>	Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.	
6	Малчин даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр	Нийтдээ 20-оос доошгүй, үүнээс 15 жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн - Нийтдээ 20-оос доошгүй, үүнээс 12 жил 6 сар малчнаар ажиллаж тэтгэврийн	

		даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн малчин өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.	ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр; -Даатгуулагч 1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан хөдөлмөрийн хөлснөөс тэтгэвэр тогтоолгохыг хүсвэл хөдөлмөрийн хөлсний тодорхойлолт -Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулсан тухай нийгмийн даатгалын байгууллагаас олгосон баримт, лавлагаа -Иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл лавлагаа -Тухайн үед оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт -Малчнаар ажилд томилсон, чөлөөлсөн тухай тушаал, эсхүл хөлсөөр ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, эсхүл тэдгээртэй адилтгах гэрээ -1995 оноос хойш малчнаар ажилласныг нотлох “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын бүртгэл, лавлагаа -2 хувь цээж зураг /3x4/
ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ			
7	<u>Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж</u>	Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 ба түүнээс дээш сар шимтгэлээ төлсөн байх 5 хүртэл жил- 50 % 5-14 жил- 55 %	-Өргөдөл -Иргэний үнэмлэхний хуулбар -Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон эмнэлэгийн акт

		15 ба түүнээс дээш жил- 75 % хувь хэмжээгээр тооцож олгоно.	
8	<u>Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж</u>	-Нийтдээ 12 сараас доошгүй, сүүлийн 6 сар тасралтгүй төлсөн байх /жирэмсний чөлөө авахаас өмнө/ Хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно --Хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй	-Нийгмийн даатгалын дэвтэр -Эмнэлгийн хуудас -Иргэний үнэмлэхний хуулбар -Эмчлүүлэгчийн карт / Албан журмын даатгуулагч-100%/ / Сайн дурын даатгуулагч-70%/ хувиар тооцож олгоно
9	<u>Оршуулгын тэтгэмж</u>	-Нийтдээ 36 сараас доошгүй /Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр -Нийгмийн даатгалын байгууллага нь нас барсан даатгуулагчийн оршуулгад зориулан түүний ар гэрт 1 000 000 төгрөгийн тэтгэмжийг (НДҮЗ-2016 оны 16 дугаар тогтоол) нэг удаа олгоно.	-Нас барсан даатгуулагчийн хөдөлмөрийн дэвтэр -Нас барсан даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтэр -Нас барсны гэрчилгээ -Өргөдөл
10	АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ	-Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр гарахаас өмнө 24 сараас доошгүй хугацаанд төлсөн байх -Үүнээс сүүлийн 9 сард нь шимтгэлийг тасралтгүй төлсөн байх -Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сараас доошгүй хугацаагаар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ -5 хүртэл жил-45% 5-10 хүртэл жил-50% 10-15 үртэл жил-60% 15 ба түүнээс дээш жил-70% тооцож олгоно	-Тэтгэмж авах тухай өргөдөл -Иргэний үнэмлэх, түүний хуулбар -Нийгмийн даатгалын дэвтэр -Ажлаас халсан тухай шийдвэр -Ажилгүй болсноо хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн тухай мэдэгдэх хуудас

11	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмж	Дараахь нөхцөл байдалд гарсан үйлдвэрлэлийн осолд даатгуулагч өртсөн тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно. -Ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх явцад -Ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед -Ажилдаа ирэх, буцах замд Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдвал түүнд энэ даатгалд шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан тэтгэвэр, тэтгэмж олгоно.	-Нийгмийн даатгалын дэвтэр -1995 оноос өмнө ажиллаж байсан даатгуулагч хөдөлмөрийн дэвтэр -Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын акт -Үйлдвэрлэлийн ослын акт -Даатгуулагчийн иргэний үнэмлэх -2 хувь цээж зураг /3х4/ -Өргөдөл
----	--	--	--